



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/103

Номгон

Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг  
хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоолын 1,2,3 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2022 оны 95/280 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Автомашины хэрэглээг хуулиар хязгаарласантай холбогдуулан суудлын автомашин ашиглах эрх бүхий албан тушаалтны, албан хэрэгцээний авто машинаас бусад орон нутгийн өмчид бүртгэлтэй автомашиныг тогтоосон хугацаанд батлагдсан хуваарийн дагуу заасан байршилд татан төвлөрүүлж, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх арга хэмжээ авахыг бүх шатны төсвийн шууд захирагч, орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, төсвөөс санхүүжилт авдаг бүх байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2.“Орон нутгийн өмчит байгууллага, хуулийн этгээд тээврийн хэрэгслийг ашиглаж, эзэмших журам”-ыг нэгдүгээр, “Албан тушаалын, албан ажлын суудлын авто машины тоо, төрөл, автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг”-ыг хоёрдугаар, журмаар зөвшөөрөгдөөгүй, илүүдэлтэй авто машинуудын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-ийн дагуу орон нутгийн өмчид бүртгэлтэй авто тээврийн хэрэгслийг бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаартай болгож, тээврийн хэрэгслийн гэрчилгээний зөрчлийг арилгах ажлыг шуурхай зохион байгуулж, ажиллахыг нийт сумдын Засаг дарга, орон нутгийн өмчит байгууллага, хуулийн этгээдийн дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.


642310249

2.

4. Журамд заагаагүй илүүдэлтэй авто машинуудыг 2023 оны 03 дугаар сард багтаан татан төвлөрүүлж, авто машины дутагдалтай байгууллагад шилжүүлэх, бусад авто машиныг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Ц.Идэрмөнх)-д, шилжилт хөдөлгөөнд орж буй автомашины бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, эд ангийг солих, дутагдахаас сэргийлж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн дэд хурандаа (Б.Мөнхбаяр)-д тус тус даалгасугай.

5. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/409 дүгээр захирамжийг хүчингүйд тооцсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2018 оны 02 дугаар  
сарын 17 ны өдрийн 17/02 дугаар захирамжийн  
нэгдүгээр хэвсрэлт

## ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН АЛБАН АЖЛЫН ХЭРЭГЦЭЭНД АВТОМАШИН АШИГЛАХ ЖУРАМ

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Орон нутгийн өмчит байгууллагуудад ашиглагдаж байгаа суудлын автомашин болон авто тээврийн хэрэгслийг зөвхөн зориулалтын дагуу ашиглуулах Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.3, 6.3, 6.5.19-д тус тус заасны дагуу эрх бүхий этгээд албан үүргийн дагуу автомашин ашиглах /цаашид “албан ажлын хэрэгцээний автомашин” гэх/ зохицуулалт, хэрэглээний хязгаарыг тогтоох, байгууллага, албан тушаалтны үүрэг, түүнд тавих хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

**Хоёр.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн автотээврийн хэрэгслийн таних тэмдэг**

2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-д заасан таних тэмдэг хэрэглэнэ.

**Гурав. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн автомашины зориулалт**

3.1.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн суудлын автомашиныг зориулалтаар нь “албан тушаалын, албан ажлын хэрэгцээний” гэж ангилан тогтоож, “Албан тушаалын болон албан ажлын хэрэгцээний суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан жагсаалтыг мөрдөж ажиллана.

3.2.Албан тушаалын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга нар байна.

3.3.Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтаны суудлын автомашины хэрэглээ аймгийн төв дотор хоногт 60 км, Албан ажлын хэрэгцээний автомашины хэрэглээ 50 км байна.

3.4.Энэхүү журмын 3.2-т зааснаас бусад албан газар, байгууллагууд Албан ажлын хэрэгцээний суудлын автомашин хэрэглэнэ.

**Дөрөв.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн автомашины эзэмшилт, ашиглалт**

4.1.Энэхүү журмыг орон нутгийн өмчит хуулийн этгээдүүд дагаж мөрдөн ажиллана.

## 2.

4.2. Байгууллагын албан ажлын хэрэгцээний автомашиныг албаны зориулалтын дагуу ашиглана.

4.3. Байгууллага бүр тээврийн хэрэгслийн тухайн оны судалгааг батлагдсан маягтын дагуу гаргаж дараа оны 02 дугаар сарын 02-ны дотор Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

4.4. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн хувийн хэрэг /автомашинд хийсэн их болон урсгал засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл, тээврийн хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөрийг төлсөн болон техникийн үзлэгт орсон талаарх эрх бүхий этгээдийн хийсэн тэмдэглэл, гарын үсэг, тамга бүхий хэсгийн хуулбар зэргийг заавал оруулсан байна./-ийг тогтмол хөтөлж баяжилтыг тухай бүр хийсэн байна.

4.5. Тухайн байгууллагад бүртгэлтэй бүх тээврийн хэрэгслийн гэрчилгээ зөрчилгүй, тухайн байгууллагын нэр дээр бүртгэлтэй байна.

4.6. Тухайн байгууллагад бүртгэлтэй механизмын хувьд техник ашиглалтын паспортыг хөтөлж журмын 4.5, 4.6-р заалтуудыг дагаж мөрдөнө.

4.7. Улсын болон орон нутгийн төсөв, хандив бэлэглэл, төсөл хөтөлбөр, сум, аймгийн орон нутаг хөгжүүлэх сан, нөөц хөрөнгө, үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, бусад эх үүсвэрээр бэлтгэсэн автомашиныг тухайн байгууллагын нэр дээр бүртгэж, тээврийн хэрэгслийн гэрчилгээг шилжүүлэн авсан нөхцөлд энэхүү журмыг мөрдлөг болгоно.

4.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээд энэхүү журмын 4.7-д заасан эх үүсвэрээр автомашин шинээр худалдан авсан бол ашиглаж байсан тээврийн хэрэгслээ Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгнө.

4.9. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн үйл ажиллагаа, чиг үүрэгт өөрчлөлт орсон, ажлын цар хүрээ нэмэгдсэн, багассан, бүтцийн өөрчлөлт хийснээс шалтгаалан суудлын автомашин нэмж авах, цөөрүүлэх зайлшгүй шаардлага гарвал автомашины тоо, төрөл тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай саналаа Орон нутгийн өмчийн газарт ирүүлнэ.

4.10. Орон нутгийн өмчит хуулийн этгээд тээврийн хэрэгсэл худалдан авах тухай бүр Орон нутгийн өмчийн газраас зөвшөөрөл авна.

**Тав. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн автотээврийн хэрэгсэлд тавих хяналт**

5.1. Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө

3.

бүхий улсын дугаар хэрэглээгүй тохиолдолд тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх үүргийг аймгийн Цагдаагийн газар, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний зөрчилтэй автомашиныг техникийн улсын үзлэгт оруулахгүй байх үүргийг аймгийн Автотээврийн төв тус тус хүлээнэ.


### **Зургаа. Бусад**

6.1.Төрийн байгууллагын албан тушаалтан хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд эрхлэх асуудлын хүрээний болон харьяа байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдээс автомашин гаргуулан ашиглах, шатахуун болон жолоочийн зардлыг төлүүлэхийг хориглоно.

6.2.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж, учруулсан хохирол, төлбөрийг нөхөн төлүүлнэ.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 1703 дугаар захирамжийн хөёрдугаар хавсралт



**АЛБАН ТУШААЛЫН, АЛБАН АЖЛЫН СУУДЛЫН АВТОМАШИНЫ  
ТОО, ТӨРӨЛ, АВТОМАШИН ХЭРЭГЛЭХ ЭРХ БҮХИЙ АЛБАН  
ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ**


№	Аймаг, сумын нэр	Байгууллагын нэр	Албан тушаалын	Албан ажлын хэрэгцээнд
1	2	3	4	5
1	Баянхонгор аймаг	ИТХ	1	1
2	Баянхонгор аймаг	ИТХ		1
3	Баянхонгор аймаг	Засаг даргын Тамгын газар	1	
4	Баянхонгор аймаг	Засаг даргын Тамгын газар		4
5	20 сум	Засаг даргын тамгын газар	1	
6		Засаг даргын тамгын газар		1
7	20 сум, Шаргалжуут 8-р баг	Эрүүл мэндийн төв		1
8	Баянхонгор	Орон нутгийн өмчийн газар		2
9	Баянхонгор	Боловсролын газар		1
10	Баянхонгор	Эрүүл мэндийн газар		1
11	Баянхонгор	Төр нийгмийн зүтгэлтэн Сономын Лувсанвандангийн нэрэмжит Аймгийн Хөгжимт драмын театр		2
12	Баянхонгор	Хүүхдийн тэмүжин театр		1
13	Баянхонгор	Гэр бүл хүүхэд залуучуудын газар		1
14	Баянхонгор	Байгаль орчин аялал, жуулчлалын газар		2
15	Баянхонгор	Аймгийн туух угсаатны зүйн музей		1
16	Баянхонгор	Нийтийн номын сан		1
17	Баянхонгор	Монгол улсын арслан П.Аюушийн нэрэмжит Биеийн тамир спортын газар		2
18	Баянхонгор	Зооноз өвчин судлалын төв		2
19	Баянхонгор	Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтэс		1
20	Баянхонгор	Ахмад настны асрамж үйлчилгээний төв		1
21	Баянхонгор	Санхүүгийн хяналт аудитын алба		1
22	Баянхонгор	Сум дундын ойн анги		1
23	Баянхонгор	Аймгийн цагдаагийн газар		25
24	Баянхонгор	Нэгдсэн эмнэлэг		10
25	Баянхонгор	Эрүүл мэндийн газар		2
26	Баянхонгор	Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК		6
27	Баянхонгор	Чандмань-Баянхонгор ХК		4
28	Баянхонгор	Баянхонгор тохижилт үйлчилгээ		1
29	Баянхонгор	Цэвэр хот ОНӨААТҮГ газар		1

2.

1	2	3	4	5
36	Баянхонгор	"Оточ номгон" өрхийн эмнэлэг		1
37	Баянхонгор	"Наранмандал" өрхийн эмнэлэг		1
38	Баянхонгор	"Энх бүрд" өрхийн эмнэлэг		1
39	Баянхонгор	"Оточ мандал" өрхийн эмнэлэг		1
40	Баянхонгор	Цаг уур орчны шинжилгээний газар		2
41	Баянхонгор	Хүнс хөдөө аж ахуйн газар		2
<b>Нийт тоо</b>			<b>3</b>	<b>85</b>

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Аймгийн Засаг даргын ... оны ... дугаар  
сарын ... ны өдрийн ... дугаар  
захирамжийн гуравдугаар хэвсрэлт



**ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ АВТО МАШИНЫ  
ЖАГСААЛТ**

№	Сум, дүүрэг	Ашиглагч байгууллагын нэр	Автомашины нэр	Улсын бүртгэлийн	
				Сери	Дугаар
1	2	3	4	5	6
1	Баянхонгор	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Lexus-470	БНА	26-13
2	Баянхонгор	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Hummer	БНР	04-44
3	Баянхонгор	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Lexus-470	БНА	86-63
4	Баянхонгор	Аймгийн Засаг даргын Тамгын газар	Caravan	БНХ	99-02
5	Баянхонгор	Сумын Засаг даргын Тамгын газар	Toyota Spacio	БНХ	81-57
6	Баянхонгор	Сумын Засаг даргын Тамгын газар	Nissan ADVAN	БНХ	00-37
7	Баянхонгор	Сумын Засаг даргын Тамгын газар	Nissan AD	БНА	58-50
8	Баянхонгор	Сумын Засаг даргын Тамгын газар	Nissan AD	БНН	20-03
9	Баянхонгор	Сумын Засаг даргын Тамгын газар	MAZDA-Famillia	бна	28-05
10	Баянхонгор	Сумын Засаг даргын Тамгын газар	Nissan AD	БНН	03-94
11	Баянхонгор	Сумын Засаг даргын Тамгын газар	MAZDA-Famillia	БНА	77-32
12	Баянхонгор	Сумын Засаг даргын Тамгын газар	Nissan AD	БНХ	00-50
13	Баянхонгор	Сумын Засаг даргын Тамгын газар	MITSUBISHI-Lancer	БНН	19-03
14	Баянхонгор	Сумын Засаг даргын Тамгын газар	Nissan AD	БНХ	00-36
15	Шинэжинст	Засаг даргын Тамгын газар	УАЗ пермер	бнх	25-40
16	Шинэжинст	Соёлын төв	УАЗ-Фургон	БНХ	20-37
17	Шинэжинст	ЭМТ	УАЗ, 220692	БНХ	16-55
18	Баян-Өндөр	Засаг даргын Тамгын газар	УАЗ220692-033	БНХ	29-71
19	Баян-Өндөр	Засаг даргын Тамгын газар	toyota Succeed-XP50	БНН	19-76
20	Баянцагаан	ЗДТГ	UAZ390942-018	БНХ	27-91
21	Баянцагаан	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Фургон /УАЗ-220692-033/	БНХ	53-28
22	Баянцагаан	Эрүүл мэндийн төв	УАЗ2206920	БНА	46-55
23	Баянцагаан	Соёлын төв	Toyota Hiaci	БНХ	18-03



1	2	3	4	5	6
24	Баацагаан	Засаг даргын Тамгын газар	УАЗ	БНХ	42-40
25	Баацагаан	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	УАЗ-469	БНА	63-91
26	Баацагаан	Ерөнхий боловсролын сургууль	Пургон	БНА	27-53
27	Бөмбөгөр	Засаг даргын Тамгын газар	фургон хагас ачааны	БНХ	32-14
28	Бөмбөгөр	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Alphard	БНА	70-08
29	Бөмбөгөр	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	УАЗ фургон	БНА	27-32
30	Бөмбөгөр	Соёлын төв	Хуандай Старех	БНА	46-14
31	Бөмбөгөр	Ерөнхий боловсролын сургууль	Хуандай Старех	БНА	46-24
32	Бууцагаан	Засаг даргын Тамгын газар	УАЗ 390942-018	БНХ	29-49
33	Бууцагаан	Засаг даргын Тамгын газар	Уаз фургон	БНХ	35-51
34	Бууцагаан	Соёлын төв	Toyota Naice	БНА	05-54
35	Хүрээмарал	Засаг даргын Тамгын газар	УАЗ-315122	БНХ	06-07
36	Хүрээмарал	Засаг даргын Тамгын газар	УАЗ-390942-018	БНА	98-05
37	Хүрээмарал	Засаг даргын Тамгын газар	Пургон	БНХ	47-82
38	Хүрээмарал	Соёлын төв	Toyota Naice	БНХ	03-87
39	Хүрээмарал	Эрүүл мэндийн төв	УАЗ-31512	БНХ	93-13
40	Баянбулаг	Засаг даргын Тамгын газар	УАЗ Пургон	БНХ	26-25
41	Баянбулаг	Засаг даргын Тамгын газар	УАЗ Пургон	БНХ	47-92
42	Баянбулаг	Соёлын төв	Toyota Naice	БНА	03-87
43	Гурванбулаг	Засаг даргын Тамгын газар	УАЗ Фургон /фермер/	БНА	29-75
44	Гурванбулаг	Соёлын төв	Toyota Naice	БНХ	73-13
45	Галуут	Засаг даргын Тамгын газар	УАЗ 469	БНА	95-58
46	Галуут	Засаг даргын Тамгын газар	УАЗ Пургон	БНХ	65-67
47	Галуут	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Ланд 105 авто машин	БНА	38-37
48	Галуут	Ерөнхий боловсролын сургууль	УАЗ-Пургон автомашин	БНХ	18-81
49	Баянхонгор	Орон нутгийн өмчийн газар	УАЗ-Пургон	БНХ	50-08
50	Баянхонгор	Орон нутгийн өмчийн газар	Ланд-100	БНР	11-34
51	Баянхонгор	Боловсрол, соёл, урлагын газар	КНА КАРНИВАЛ Маркаар /он/	БНН	05-51
52	Баянхонгор	Эрүүл мэндийн газар	Хтерал түргэн тусламжийн автомашин	БНХ	44-46
53	Баянхонгор	Эрүүл мэндийн газар	Ниссан Патрол Y-61	БНХ	65-55
54	Баянхонгор	Эрүүл мэндийн газар	Фургон автомашин	БНА	67-71

1	2	3	4	5	6
55	Баянхонгор	Төр нийгмийн зүтгэлтэн Сономын Лувсанвандангийн нэрэмжит Аймгийн хөгжимт драмын театр	Land 470	БНХ	07-43
56	Баянхонгор	Ахмад настны асрамж үйлчилгээний газар	Старекс	БНХ	24-43
57	Жинст	Засаг даргын Тамгын газар	МЭҮТасгийн автомашин	БНХ	28-79
58	Богд	Засаг даргын Тамгын газар	Супер УАЗ машин	БНХ	37-80
59	Богд	ЭМТ	Супер УАЗ машин	БНХ	18-78
60	Баянлиг	Ерөнхий боловсролын сургууль	Старекс	БНХ	49-95
61	Баянлиг	Соёлын төв	TOYOTA HIACE	БНХ	29-11
62	Баянговь	Засаг даргын Тамгын газар	УАЗ 512	БНХ	25-25
63	Жаргалант	Засаг даргын Тамгын газар	ланд-100	БНА	44-00
64	Баян-Овоо	Засаг даргын Тамгын газар	Ланд крузор-105	БНР	16-01
65	Баян-Овоо	Засаг даргын Тамгын газар	Цагдаагийн машин /румон/	БНЗ	73-86
66	Баян-Овоо	Засаг даргын Тамгын газар	Хагас пургон	БНХ	29-46
67	Баян-Овоо	Засаг даргын Тамгын газар	Фургон	БНР	98-90
68	Баян-Овоо	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Ланд крузор-80	БНХ	69-31
69	Баян-Овоо	Ерөнхий боловсролын сургууль	Пургон	БНН	00-97
70	Баян-Овоо	Соёлын төв	NISSAN CARAVAN	УНВ	92-81
71	Эрдэнэцогт	Засаг даргын Тамгын газар	Уаз-фургон автомашин	БНХ	28-23
72	Өлзийт	Засаг даргын Тамгын газар	УАЗ	БНХ	26-76
73	Өлзийт	Засаг даргын Тамгын газар	Probox	БНА	01-30.
74	Өлзийт	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Делика D-5	БНА	07-77
75	Өлзийт	Ерөнхий боловсролын сургууль	TOYOTA hiace маркийн микробус	БНХ	47-43
76	Өлзийт	Соёлын төв	УАЗ-фургон	БНХ	41-85
77	Заг	Засаг даргын Тамгын газар	УАЗ	БНХ	29-35
78	Заг	Соёлын төв	Toyota Alphard	БНА	32-14